



ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ИРГЭДИЙН ДАХИН СУРАЛЦАХАД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Ц.Ганцэцэг

МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш

Abstract: There are many factors of the reason why she/he, who had already graduated from the university, or entered another university to study again. These people take evening classes because they can't find jobs in their field. Due to the influence and pressure from parents, some of them couldn't choose the majors they were interested in. Also, their test score wasn't good enough to study in the field they wanted to. Therefore, they study again for the reasons of getting promoted to a higher position or of getting a better salary at their current job.

Түлхүүр үг: дахин суралцах, ажил эрхлэлт, сургалтын чанар, цалин

Нэг. Их, дээд сургуульд дахин элсэгчдийн онцлог шинжүүд

Манай улсад их, дээд сургууль төгссөн боловч эзэмшсэн мэргэжлээрээ төдийлэн ажиллахгүй байх, эсвэл хэсэг хугацаанд ажиллаад мэргэжлээрээ солих зорилгоор дахин суралцаж буй явдал нэлээд байгаа бөгөөд энэ нь ямар шалтгаантайг илрүүлэх, улмаар дүгнэлт хийж, санал дэвшүүлэхэд судалгааны зорилго оршиж байв.

Манай улсын олон их, дээд сургууль орой, эчнээ салбарт оюутан элсүүлэн сургадаг олон жилийн туршлагатай. Бид судалгаандаа МУИС-ийн Бизнесийн сургуулийн орой, эчнээ ангид суралцагчдыг судалгаандаа хамруулсан бөгөөд оюутнуудаас хоёр дахь удаагаа дээд боловсрол эзэмших болсон шалтгааныг ярилцлагын болон санал асуулгын хуудсаар судлав.

МУИС-ийн Бизнесийн орой, эчнээ

салбарт 2014-2015 оны хичээлийн жилд 530 оюутан санхүүгийн менежмент, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодогч, гадаад худалдаа, гаалийн удирдлага мэргэжлээр суралцаж байна. Судалгаанд 135 оюутан буюу суралцагчдын 25.4 хувь хамрагдсан болно.

Өмнө нь их, дээд сургуульд төгсч мэргэжил эзэмшсэн атлаа дахин суралцаж буй оюутнуудын онцлог шинжүүдийг үзвэл дараах байдалтай байв.

1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцааг үзвэл эрэгтэй 20 хувь, эмэгтэй 80 хувь байна. Их, дээд сургуульд суралцагчдын ихэнх хувь эмэгтэйчүүд байдаг явдал орой, эчнээ салбарын суралцагчдын хувьд мөн давтагдаж байгаа нь суралцагчдын, цаашлаад ажлын байранд хүйсийн тэнцвэр алдагдсаныг харуулж байна гэж үзэв.

2. Судалгаанд оролцогчдын насны бүтцийг үзвэл суралцагчдын 32 хувь нь 21-25 настай, 58 хувь нь 26-35 настай, 10 хувь нь 36-40 настай байв.

3. Судалгаанд оролцогчдын өрхийн нэг сарын дундаж орлогын түвшин (*төгрөг*)

500.0 мян.төг. хүртэл	10 хувь
501.0-750.0 мян.төг.	24 хувь
751.0 мян.төг -1.0 сая.төг.	31 хувь
1.1 сая.төг. - 2.0 сая төг.	22 хувь
2.1 сая төг. - 3.5 сая төг.	6 хувь
3.51 сая төг. – 5.0 сая төг	5 хувь
5.1 сая төг-өөс дээш	1 хувь

Суралцагчдын 10 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэл сарын орлоготой байгаа нь

элсэгчдийн 23 хувь суралцах хугацаандаа ажил эрхлээгүй байгаа, зарим нь ажил олдохгүй, зарим нь хүүхэд төрүүлэн гэртээ сууж байх үедээ суралцаж байгаатай холбоотой байна.

Мөн 55 хувь нь 500.0 мян.төг -1.0 сая. төг. хүртэл орлоготой байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм.

Энэ нь тэдний өмнө эзэмшсэн мэргэжлийн ажлын байр хангалттай бус, өөрийн хүсэл сонирхлоор суралцаж төгсөөгүй зэргээс өөр мэргэжлийн ажил эрхлэх явдал байдаг, үүнтэй холбоотойгоор цалин төдийлөн сайнгүй байна гэж үзэв.

Хэдийгээр ийнхүү хангалттай бус орлоготой боловч дахин дээд боловсрол олохоор тэмүүлж байгаа нь амьдралаа дээшлүүлэх хэрэгцээнээс үүдэлтэй байна.

Суралцагчдын 22 хувь нь 1.1-2.0 сая төгрөгийн орлоготой байгаа нь сургалтын төлбөр, бусад зардлыг төлөхөд боломжийн харагдаж байна.

Харин 2.1-5.0 сая төгрөгийн орлоготой суралцагч нийлээд 11 хувь болж байгаа бөгөөд харьцангуй боломжийн үзүүлэлт юм.

Судалгаанд 5.1 сая төгрөгөөс дээш орлоготой суралцагч нэг хувийг эзэлж байгаа нь нийт иргэдийн дунд өндөр орлоготой цөөн өрх байдгийг харуулж байна.

4. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал:

Төрийн байгууллага	18 хувь
Төрийн бус байгууллага	7 хувь
Хувийн байгууллага	37 хувь
Хувийн бизнес эрхэлдэг	15 хувь
Одоогоор ажил эрхэлдэггүй	23 хувь

Бүдүүвч 1

Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал




Суралцагчдын 37 хувь нь хувийн байгууллагад, 15 хувь нь хувийн жижиг бизнес эрхэлдэг, 18 хувь нь төрийн байгууллагад ажиллаж байна. Мөн 7 хувь нь төрийн бус байгууллагад ажилладаг, харин 23 хувь нь ажил эрхлээгүй байгаа ажээ.

5. Дахин суралцагчдын өмнө төгссөн сургуулийг үзэхэд 40 хувь МУИС төгссөн, 17 хувь нь ШУТИС төгссөн, 11 хувь нь ХААИС төгссөн, 7 хувь нь ИЗИС төгссөн, 12 хувь нь хувийн бусад их, дээд сургууль төгсчээ. МУИС болон ШУТИС-ийн төгсөгчид дахин суралцах явдал илүү байна.

Бүдүүвч 2


Судалгаанд оролцогчдын өмнө төгссөн сургууль



1. Дахин суралцагчдын 51 хувийг инженер (28 хувь), орчуулагч (9 хувь), програм хангамжийн инженер (7 хувь), багш (7 хувь) гэсэн үндсэн 4 мэргэжлийн хүмүүс эзэлж байна. (Бусад мэргэжлийн суралцагчдыг зураг 3-т үзүүлэв)

Бүдүүвч 3

Судалгаанд оролцогчдын өмнө эзэмшсэн мэргэжил



Хоёр. Элсэгчдийн их, дээд сургуульд дахин элсэн суралцсан шалтгаан (орой, эчнээ салбарт)

1. Орой, эчнээ ангийн оюутнуудын дахин суралцаж буй шалтгааныг үзвэл, тэдний 55 хувь нь өөр мэргэжлээр суралцах зайлшгүй хэрэгцээ гарсан байна. Мөн ажиллаж буй салбарын мэргэжил эзэмшвэл цалин нэмүүлэх болон албан тушаал ахих (тус бүр 8 хувь)

боломж гарна гэж үзсэн; өмнөх эзэмшсэн мэргэжил өнөөгийн шаардлага хангахгүй болсон (5 хувь); хувийн бизнес эрхлэх болсон тул бизнесийн чиглэлээр суралцах болсон (11 хувь); орчин үеийн шинэ мэдлэг боловсрол олж авах (13 хувь) зэрэг шалтгаанаар дахин суралцаж байгаа ажээ.


Судалгаанд оролцогчдын 77 хувь нь ажил эрхлэхийн зэрэгцээ орой, эчнээгээр цаг зав гарган, зохих төлбөр төлөн суралцаж байна. Өөр мэргэжлээр суралцах шаардлагын дагуу суралцаж буй хүмүүс нийт оюутнуудын талаас илүү хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм. Гадаад худалдаа, гаалийн удирдлага мэргэжлээр суралцагчид үндсэндээ албан тушаал ахих зорилгоор элссэн бол бусад мэргэжлээр суралцагчид ихэвчлэн одоогийн эрхэлж буй ажилдаа тогтвортой ажиллах, улмаар цалин нэмүүлэх горьдлого өвөрлөдөг байна.

Түүнчлэн өмнөх мэргэжлээрээ ажиллах сонирхол, боломжгүй байгаа нь анхнаасаа хүсэл сонирхол, авьяасыг харгалзан сонгоогүй явдал дахин дээд сургуульд элсэн суралцах бас нэг шалтгаан болдог байна.

2. Орой, эчнээ ангид суралцагчид МУИС-ийн Бизнесийн сургуулийг сонгох болсон шалтгааныг үзэхэд 55 гаруй хувь нь чанартай боловсрол олгодог, 24 хувь нь төгсөөд ажил олдох магадлал сайтай, 20 хувь нь нэр хүндтэй, нэг хувь нь ажилд ойрхон гэсэн үзүүлэлтээр сонгон элсчээ. Үүнийг дээд сургууль төгссөн туршлагатай хүмүүс дахин суралцахдаа тавьдаг нийтлэг шалгуур гэж үзэж болох юм. Орой, эчнээ ангийн элсэгчид МУИС-ийн Бизнесийн сургуулийг сонгосон нь МУИС-ийн хувьд нэр хүнд, чанартай боловсрол, төгсөгчид ажлын байр сайн олддог гэсэн хоногшилт иргэдийн дунд байдгийг харуулж байна.

Бүдүүвч 4

Судалгаанд оролцогчдын суралцах сургуулийг сонгосон үзүүлэлт




3. Элсэгчид мэргэжил сонголтын байдлыг үзвэл 38 хувь нь нягтлан бодох бүртгэл, 25 хувь нь санхүүгийн менежмент, 7 хувь нь маркетинг, 6 хувь нь гадаад худалдаа, гаалийн удирдлага, 24 хувь нь ня-бо хяналт шалгалтын мэргэжлийг тус тус сонгожээ. Эндээс үзвэл элсэгчдийн тал хувь нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг илүү сонирхон сонгодог нь харагдаж байна. Энэ нь нягтлан бодогчийн ажил албан тушаал бүхий л байгууллагад байдаг, төгсөгчид банк, санхүүгийн байгууллагад ажиллах боломж өндөр, тэрчлэн хувийн бизнес эрхлэгчдийн хувьд нягтлан бодогчийн мэргэжлийг чухал гэж үздэгтэй холбоотой юм.



Бүдүүвч 5

Элсэгчдийн мэргэжил сонголт




Гурав. МУИС-ийн Бизнесийн сургуулийн орой, эчнээ ангид суралцагчдын сэтгэл ханамжийн байдал

1. Орой, эчнээ ангийн суралцагчид сургалтын чанарыг хэрхэн үнэлснийг үзвэл 21 хувь нь маш сайн, 61 хувь нь боломжийн, 16 хувь нь дунд зэрэг, 2 хувь нь хангалтгүй гэж үзжээ. Орой ангийн суралцах хугацаа богино, эчнээ ангийн хувьд богино хугацаанд хичээлийг шахаж үздэг, суралцагчдын 80 шахам хувь ажил эрхэлдэг зэрэг шалтгаанаас сурлагын чанар зарим үед төдийлэн сайнгүй байж болох талтай. Гэвч өмнө дээд сургууль төгссөн туршлагатай суралцагчид байдаг учир мэдлэг чадвар сайтай, гадаад хэлний мэдлэгийн түвшин өндөр суралцагчид нэлээд байдгийг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд үнэлгээг үндэслэл сайтай өгсөн гэж үзэж байна.

Бүдүүвч 6

Орой /эчнээ/ ангийн хөтөлбөрийн чанарын үнэлгээ




2. Орой, эчнээ ангид суралцагчид одоогийн суралцаж буй сургууль, мэргэжилдээ аль хэр сэтгэл ханамжтай байгаа талаар судалж үзэхэд 87 хувь нь сэтгэл ханамжтай гэсэн боловч 13 хувь нь төдийлөн сэтгэл ханамжтай бус байдаг ажээ.

Хэрэв хоёр дахь удаа дээд сургуульд суралцаж байгаа хэрнээ сэтгэл ханамжтай бус байгаа бол мэргэжил сонголтыг буруу хийсэн, эсвэл ажил эрхэлж байгаа зэргээс үүдэн хичээл хийх боломжгүй зэрэгтэй холбоотой байж болох талтай.

Ямартай ч эдгээр оюутан энэ байдалдаа сайтар дүгнэлт хийж хойшид хэрхэх тухай бодох нь зүйтэй.

Бүдүүвч 7


Судалгаанд оролцогчдын сэтгэл ханамжийн байдал



3. Суралцагчид багш нарын заах аргад ерөнхийд нь ямар үнэлгээ өгч байгаа тухай асуухад 84 хувь нь сайн, 16 хувь нь дунд зэрэг гэж үнэлжээ. Энэ үзүүлэлт нь багш нар хичээлээ үндсэндээ сайн заадаг, багшийн заах арга боломжийн, багш оюутны уялдаа холбоо сайн гэдгийг харуулж байгаа боловч энэхүү шаардлагыг хангаагүй багш нар байгааг анхаарах хэрэгтэй.

Бүдүүвч 8

Багш нарын заах аргыг ерөнхийд нь үнэлсэн үнэлгээ



4. Суралцагчид сургуулийн орчин нөхцөлийг 40 хувь нь сайн, 54 хувь нь дунд зэрэг, 6 хувь нь хангалтгүй хэмээн үнэлжээ. МУИС-ийн Бизнесийн сургуулийн анги бүр проектор, компьютерээр тоноглогдсон, компьютерийн лабораториуд сүүлийн үеийн шинэ компьютертэй, хүрэлцээ сайтай байдаг нь оюутнууд лекц, семинарын хичээлээс гадна ангид хичээл давтах боломжоор хангагдсан холбоотой юм. Дунд зэрэг болон хангалтгүй хэмээн үнэлсэн оюутнууд *WiFi* байнга хэвийн ажилладаггүй учир ийнхүү үнэлж байгааг тодруулсан байна.

5. Сургалтын төлбөрийн хувьд суралцагчдын 12 хувь нь харьцангуй өндөр, 88 хувь нь боломжийн үнэтэй гэж үзжээ. Энэ нь элсэгчдийн өрхийн орлогын түвшин боломжийн байгаа бөгөөд МУИС-ийн төлбөр хэт үнэтэй бус байгааг харуулж байна гэж үзэж болно. МУИС-ийн 1 кредит/цагийн төлбөрийг СЭЗДС-ийн төлбөртэй харьцуулахад 40 хувиар хямд байна. (Жишээ нь: МУИС-ийн 1 кредитийн төлбөр 69.0 мян.төг, СЭЗДС-ийн 1 кредитийн төлбөр 117.0 мян.төг.)


6. Сургалтын төлбөр сургалтын чанартай хэрхэн нийцэж байгаа талаар судлахад сургалтын төлбөр харьцангуй өндөр үнэтэй гэж хариулсан оюутнуудын 2 хувь нь маш сайн, 6 хувь нь боломжийн, 4 хувь нь дунд зэрэг гэж хариулжээ. Харин сургалтын төлбөр боломжийн үнэтэй гэж хариулсан оюутнуудын 20 хувь нь маш сайн, 56 хувь нь боломжийн,



12 хувь нь дунд зэрэг гэж хариулжээ. Үүнээс үзвэл сургалтын төлбөр сургалтын чанартайгаа сайн нийцэж байна гэж үзэв. Суралцагчдын 80 шахам хувь нь сургалтын чанарыг харьцангуй сайн гэсэн хариулт өгснийг хангалттай гэж үзэж болно.

Зураг 9

Сургалтын төлбөр болон сургалтын чанарыг харьцуулсан үзүүлэлт



7. Орой, эчнээ ангийн оюутнуудын ихэнх нь ажил эрхэлдэг учир сургуулийн номын санд сууж хичээл хийх боломж тэр бүр байдаггүй байна. Харин номын сангийн карт нээлгэж, гэрээр олгох номын сангаар ихэвчлэн үйлчлүүлдэг ажээ. Тэдний 70 шахам хувь хичээлийн холбогдолтой ном номын санд байдаг гэжээ. Зарим нь номын сангийн карт нээлгээгүй учир номын сангаас ном авдаггүй байна. Иймд оюутнуудын номын сангийн үйлчилгээнд хамрагдах явдал зарим талаар хангалтгүй байгаа нь харагдав.

ДҮГНЭЛТ

1. Орой, эчнээ ангид суралцагчид дахин их, дээд сургуульд элсэн суралцахад өмнө эзэмшсэн мэргэжлийн хувьд ажлын байр төдийлэн хангалттай бус байдгаас мэргэжлээрээ ажиллах боломжгүй, анхнаасаа өөрийн хүсэл сонирхлоор бус гэр бүлийнхний шахалтаар хүсээгүй сургуульд элссэн, ерөнхий шалгалтын оноо хүссэн мэргэжил эзэмшихэд хангалттай бус байсан, одоогийн эрхэлж буй ажил дээрээ албан тушаал ахих, цалин хөлсөө нэмэгдүүлэх, төрийн албанд ажиллах зэрэг янз бүрийн сонирхол, хэрэгцээ шаардлагаас урган гардаг байна.

2. Дахин дээд боловсрол эзэмших сонирхолтой иргэд элсэн орох сургуулийг сонгохдоо сургуулийн нэр хүнд, чанартай боловсрол эзэмшүүлдэг эсэх, төгссөний дараа ажил олдох магадлал зэргийг голчлон авч үздэг ажээ. Элсэгчид ийнхүү сургуулийн нэр хүнд, чанартай боловсролыг харгалзан сонгож байгаа нь манай төрийн болон хувийн их, дээд сургуулиудын сургалтын чанар, орчин нөхцөл, багшлах боловсон хүчний ур чадвар харилцан адилгүй байгааг харуулж байна. Харин сургалтын төлбөрийн асуудлыг төдийлэн харгалздаггүй шалтгаан нь элсэгчдийн 80 шахам хувь нь ажил эрхэлж байгаатай холбоотой юм.

3. МУИС-ийн Бизнесийн сургуулийн хувьд нягтлан бодогч мэргэжлээр элсэгчид тал хувийг эзэлдэг нь энэ мэргэжлийн хэрэгцээ шаардлага их байгааг харуулж байна.

4. Орой, эчнээ ангид суралцагчид нь суралцах туршлага сайтай учир ихэнх нь хичээл, сурлагадаа хариуцлагатай ханддаг, үүргээ ухамсарладаг боловч ажил эрхлэхийн зэрэгцээ

суралцдаг учир номын санд суух цаг зав байдаггүй учир сурлагын чанар төдийлөн сайнгүй байдаг ажээ.

5. Суралцагчдын ихэнх нь ажил эрхэлдэг учир сургалтын төлбөрөө өөрсдөө төлөх чадвартай, төлбөрийг тэр бүр өндөр хэмээн үздэггүй байна.

САНАЛ

1. Элсэгчдийн дахин суралцах болсон шалтгаанаас үзэхэд ЕБС төгсөгчид мэргэжил сонгохдоо өөрсдийн авьяас, сонирхол дээр бус зарим үед гэр бүлийн шахалтаас болж сургуульгүй хоцрохгүйн тулд аль нэг их, дээд сургуулийг сонгож, эцэст нь мэргэжлээрээ ажиллахгүй, дахин суралцахад хүрдгийг эцэг, эхчүүд анхаарах хэрэгтэй байна. Сонирхолгүй мэргэжил эзэмшсэнээс болж дахин суралцаж цаг хугацаа, санхүүгийн байдлаар хохирох явдал байгаад дүгнэлт хийх нь зүйтэй юм.

2. Төр болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд сургалтын чанар, суралцах орчин, багшлах боловсон хүчин, сургалтын хөтөлбөр зэрэг чухал үзүүлэлт дээр жигд байх хэрэгтэй байна.

3. Орой, эчнээ ангид суралцагчид ажлаа давхар хийдэг учир байгууллагын удирдлагын зүгээс суралцагчийн чанартай суралцахад дэмжлэг үзүүлж, урамшуулах явдлыг сайжруулах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Батнасан, Н. (2014). *Бизнесийн сургуулийн захирлын ажлын тайлан*. Улаанбаатар
Дагвадорж, Д. (2007). *Маркетингийн судалгааны арга зүй*. Улаанбаатар
Отгонсүрэн, Я. (2012). *Үйлчилгээний маркетинг*. Улаанбаатар
Ганцэцэг, Ц. (2012). *Хэрэглэгчийн судалгаа хийх аргачилсан зөвлөмж*. Улаанбаатар
Баярмаа, Д. (2009). *Маркетинг*. Улаанбаатар